



МОНГОЛ УЛСЫН МЭДЭЭЛЭЛ
АГЕНС
Утас: 03 дугаар сарын 16
№11 /680/

МОНГОЛ УЛСЫН МЭДЭЭЛЭЛ АГЕНС

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХҮҮРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН
СГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ

485

МОНГОЛ УЛСЫН
СГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ

496

Журам батлах тухай

Хөтөлбөр батлах тухай

**ГАРЧИГ****МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

149.	Журам батлах тухай	Дугаар 308	485
150.	Хөтөлбөр батлах тухай	Дугаар 318	496
151.	Жагсаалт батлах тухай	Дугаар 325	507

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2010 оны 12 дугаар
сарын 1-ний өдөр

Дугаар 308

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Ашигт малтмалын тухай хуулийн 3.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ журмыг хэрэгжүүлэх талаар зохион байгуулалтын болон зохицуулалтын арга хэмжээ авахыг Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригтод, журмын хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж байхыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт, журмыг хэрэгжүүлэх ажлыг нутаг дэвсгэртээ зохион байгуулж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү журам батлагдсантай холбогдуулан "Түр журам батлах тухай" Засгийн газрын 2008 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн 72 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**ЭРДЭС БАЯЛАГ,
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД**

Д.ЗОРИГТ



Засгийн газрын 2010 оны
308 дугаар тогтоолын хавсралт

**БИЧИЛ УУРХАЙГААР АШИГТ МАЛТМАЛ
ОЛБОРЛОХ ЖУРАМ**

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Бичил уурхайн хэлбэрээр ашигт малтмал олборлох үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Энэхүү журам нь ус, цацраг идэвхт элемент агуулсан хүдэр, газрын тос, байгалийн хийгээс бусад төрлийн ашигт малтмалыг бичил уурхайн хэлбэрээр олборлох үйл ажиллагаанд хамаарна.

Хоёр. Бичил уурхайн талаархи сум, дүүргийн иргэдийн
Төлөөлөгчдийн Хурлын эрх, үүрэг

Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь дараахь эрх, үүрэгтэй байна:

2.1. Бичил уурхайн хэлбэрээр ашигт малтмал олборлох талаар нөхөрлөлөөс гаргасан хүсэлтийг хүлээн авч Газрын тухай хуулийн 16.1.11-д заасан зориулалтаар орон нутгийн тусгай хэрэгцээнд авах газрыг сонгож, солбицлыг тогтоох.

2.2. Бичил уурхайн зориулалтаар орон нутгийн тусгай хэрэгцээнд авахаар сонгож, солбицлыг тогтоосон газрын талаар Ашигт малтмалын тухай хуулийн 11.1.23-т заасан дүгнэлт гаргуулахаар геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүсэлт тавихыг зөвшөөрсөн шийдвэр гаргах.

2.3. Сонгосон газрыг бичил уурхайн зориулалтаар ашиглах боломжгүй болох нь геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын гаргасан дүгнэлтээр тогтоогдвол тухайн сум, дүүргийн нутагт бичил уурхайгаар ашиглах бололцоогүй болсон тухай шийдвэрийг ажлын 10 хоногт багтаан гаргах.

2.4. Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гаргасан шийдвэрээ иргэдэд зарлан мэдэгдэж, хэрэгжилтэд нь хяналт тавих.

Гурав. Бичил уурхайн талаархи сум, дүүргийн
Засаг даргын эрх, үүрэг

Сум, дүүргийн Засаг дарга дараахь эрх, үүрэгтэй байна:

3.1. Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийн



дагуу бичил уурхайгаар ашигт малтмал олборлох иргэдэд бүртгэгдээгүй нөхөрлөлийн зохион байгуулалтад ороход нь эрх зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлж энэ талаар үнэ төлбөргүй зөвлөгөө өгөх.

3.2. Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бичил уурхайн зориулалтаар сонгож шийдвэрлэсэн газрын талаар дүгнэлт гаргуулахаар энэхүү журмын 2.2-т заасан хүсэлтийг геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулах.

3.3. Геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас бичил уурхайн зориулалтаар ашиглаж болох тухай дүгнэлт гарсан тохиолдолд сум, дүүргийн Засаг дарга нь сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын энэхүү журмын 2.2-т заасан шийдвэрийг үндэслэн өргөдөл гаргасан нөхөрлөлтэй бичил уурхайгаар ашигт малтмал олборлох тухай гэрээг нэг жилийн хугацаагаар байгуулна. Нөхөрлөлөөс гаргасан хүсэлтийн дагуу гэрээний хугацааг нэг нэг жилээр сунгаж болно.

3.4. Сум, дүүргийн хэмжээнд бичил уурхайн зориулалтаар олгосон газрын зураг зүйн нэгдсэн бүртгэл, олборлолтын мэдээг хөтлөх.

3.5. Бичил уурхай эрхлэгчдэд эрүүл мэндийн болон нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх, хүүхдийг нь сургууль, цэцэрлэгт хамруулах арга хэмжээ авах.

3.6. Бичил уурхай эрхлэгчдийг татвар, даатгалд хамруулах ажлыг удирдлага, зохицуулалтаар хангах.

3.7. Байгаль орчныг нөхөн сэргээх талаар нөхөрлөлөөс авсан арга хэмжээ, хийсэн ажлын тайланг авч, газар дээр нь шалган, геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас баталсан зааврын дагуу нөхөн сэргээлтийн ажлыг хийлгэсний үндсэн дээр хүлээн авч, энэ тухай мэдээллийг аймаг, нийслэлийн мэргэжлийн хяналтын байгууллагад жилд 1 удаа хүргүүлж байх.

3.8. Нөхөрлөл болон сум, дүүргийн нутгийн захиргааны байгууллага нь нөхөрлөлийн олборлолт явуулсан талбайд хийгдэх техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлын зардлыг тооцож, зохих мөнгөн хөрөнгийг нөхөн сэргээлтийн дундын санд төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж, тухайн нөхөрлөлтэй хамтран захиран зарцуулах.

3.9. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомж болон геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас баталсан бичил уурхайн хөдөлмөр хамгаалал, аюулгүй



ажиллагааны дүрмийг мөрдүүлэх.

3.10. Бичил уурхай эрхлэгчдийн үйл ажиллагааны талаархи мэдээллийг батлагдсан маягтын дагуу гаргаж, геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад жил бүрийн 2 дугаар сарын 15-ны дотор хүргүүлж байх.

3.11. Энэ журмын 10.2-т заасны дагуу нөхөн сэргээлт хийгээгүй нөхөрлөл болон тус нөхөрлөлийн гишүүдийн шинээр үүсгэн байгуулсан нөхөрлөлтэй ашигт малтмал олборлох гэрээ дахин байгуулахгүй байх.

3.12. Нөхөрлөлийн буруутай үйл ажиллагааны улмаас байгаль орчинд сөрөг нөлөөлөл учирсан болох нь мэргэжлийн байгууллагаас тогтоогдсон тохиолдолд тухайн нөхөрлөлтэй байгуулсан ашигт малтмал олборлох гэрээг цуцлах.

3.13. Нөхөрлөлийн олборлолт явуулж байгаа газрын нутаг дэвсгэрт уурхайчид болон тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн амьдрах суурьшлын бүсийг тогтоож, хүрээлэн байгаа орчныг бохирдлоос хамгаалах, хог хаягдлын асуудлыг шийдвэрлэх ажлыг нэгдсэн удирдлагаар хангах.

Дөрөв. Бичил уурхайн талаар геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын эрх, үүрэг

Геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь дараахь эрх, үүрэгтэй байна:

4.1. Ашигт малтмалын тухай хуулийн 11.1.23, энэ журмын 3.2-т заасан хүсэлтийн дагуу бичил уурхайгаар ашигт малтмал олборлоход зориулан сонгосон газрын талаархи дүгнэлтийг кадастрын зураг зүйн бүртгэл, мэдээлэлд тулгуурлан, ажлын 14-21 хоногт гаргаж сум, дүүргийн Засаг даргад хүргүүлэх.

4.2. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлохыг зөвшөөрсөн тухай дүгнэлт гаргасан газрыг кадастрын зураг зүйн нэгдсэн бүртгэлд бүртгэх.

4.3. Дараахь дүрэм, заавар, маягт, загварыг батлах:

4.3.1. ашигт малтмал олборлох гэрээ байгуулах талаар сум, дүүргийн Засаг даргад нөхөрлөлөөс гаргах өргөдлийн маягт;

4.3.2. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох талаар сум, дүүргийн Засаг дарга, нөхөрлөлийн хооронд байгуулах гэрээний



үлгэрчилсэн загвар;

4.3.3. бичил уурхайгаар ашигт малтмал олборлох талаар сум, дүүргийн Засаг дарга, ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч, нөхөрлөлийн хооронд байгуулах гурвалсан гэрээний үлгэрчилсэн загвар, энэхүү гэрээний үлгэрчилсэн загварт дараахь асуудлыг тодорхой тусгана:

4.3.3.1. ашигт малтмал олборлох, борлуулах;

4.3.3.2. байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх;

4.3.3.3. хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй;

4.3.3.4. гэрээгээр ашиглуулах талбай.

4.3.4. бичил уурхайн талбайд байгаль орчны нөхөн сэргээлт хийх заавар;

4.3.5. хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм;

4.3.6. бичил уурхай эрхлэгчдийн үйл ажиллагааны талаархи мэдээллийн маягт.

4.4. нөхөрлөлийн гишүүдэд байгаль орчны болон хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаар чадваржуулах сургалт явуулж, дэмжлэг үзүүлэх.

Тав. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох газар

5.1. Бичил уурхайн зориулалтаар нөхөрлөлд эзэмшүүлэх газрын хэмжээ 5 га-гаас ихгүй байна.

5.2. Нэг сум, дүүргийн нутаг дэвсгэрт бичил уурхайн хэлбэрээр ашигт малтмал олборлоход зориулан сонгосон газрын тоо 10-аас илүүгүй байна.

5.3. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох зориулалтаар ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн уурхайн эдэлбэр газраас сум, дүүргийн Засаг дарга, тусгай зөвшөөрөл эзэмшигч, нөхөрлөлийн хооронд байгуулсан гурвалсан гэрээний дагуу нөхөрлөлд талбай ашиглуулж болно.

5.4. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн уурхайн эдэлбэр газраас бичил уурхайгаар ашигт малтмал олборлох нөхцөлд нэг



сум, дүүргийн нутаг дэвсгэрт бичил уурхайн хэлбэрээр ашигт малтмал олборлоход зориулсан газрын тоо 10-аас илүү байж болно.

5.5. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн уурхайн эдэлбэр газраас сум, дүүргийн Засаг дарга, тусгай зөвшөөрөл эзэмшигч, нөхөрлөлийн хооронд гурвалсан гэрээ байгуулсны үндсэн дээр нөхөрлөлд дагд уурхай ашиглуулж болно.

5.6. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэхүү журмын 5.3, 5.5-д заасны дагуу уурхайн эдэлбэр газраас нөхөрлөлд талбай ашиглуулсан нь Ашигт малтмалын тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасан байгаль орчныг хамгаалах талаар ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх үүргээс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.

Зургаа. Ашигт малтмал олборлох иргэдийн зохион байгуулалт

6.1. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох иргэд нь Иргэний хуулийн 476 дугаар зүйлд заасны дагуу хамтран ажиллах гэрээг бичгээр байгуулж, мөн хуулийн 481.1 дүгээр зүйлд заасан бүртгэгдээгүй нөхөрлөлийн хэлбэрээр зохион байгуулагдсан байна.

6.2. Нөхөрлөлийн үйл ажиллагаа нь Иргэний хуулийн 477-482 дугаар зүйл болон нөхөрлөлийн дүрмийн дагуу зохицуулагдана.

6.3. Нөхөрлөл нь оноосон нэртэй байна. Нэг сум, дүүргийн нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа эрхэлж байгаа нөхөрлөл нь өөр нөхөрлөлтэй давхардсан нэртэй байж болохгүй.

6.4. Нөхөрлөлийн гишүүдийн тоо нь 5-аас цөөнгүй байна.

6.5. Нөхөрлөлийн гишүүн өөр нөхөрлөлийн гишүүн байхыг хориглоно.

Долоо. Ашигт малтмал олборлох гэрээ байгуулах тухай өргөдөл гаргах

7.1. Нөхөрлөл Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох гэрээ байгуулах тухай өргөдлөө сум, дүүргийн Засаг даргад энэхүү журмын 4.3.1-д заасан маягтын дагуу бичгээр гаргана.

7.2. Өргөдөлд дараахь зүйлийг заавал тусгана:

7.2.1. нөхөрлөлийн нэр, нөхөрлөлийн ахлагч-буху зэрэг бүхий төлөөлөгч болон гишүүдийн нэр, хаяг;



7.2.2. талбайн байршил;

7.2.3. олборлох ашигт малтмалын төрөл.

7.3. Өргөдөлд дараахь баримт бичгийг хавсаргана:

7.3.1. нөхөрлөлийн гишүүдийн иргэний үнэмлэхийн хуулбар;

7.3.2. нөхөрлөлийн гишүүдийн хооронд бичгээр байгуулсан хамтран ажиллах гэрээний хуулбар;

7.3.3. олборлолт явуулах талбайн байршлын зураг;

7.3.4. нөхөрлөлийн гишүүний албан татвар төлөгчийн гэрчилгээ, дэвтрийн хуулбар;

7.3.5. нөхөрлөлийн гишүүдийн эрүүл мэнд, нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар.

7.4. Нөхөрлөлийн гишүүдэд дараахь шаардлага тавигдана:

7.4.1. Монгол Улсын иргэн байх;

7.4.2. 18 нас хүрсэн байх;

7.4.3. тухайн орон нутагт оршин суугчаар бүртгүүлсэн байх.

7.5. Энэхүү журмын 7.1-7.4-т заасан шаардлага хангаагүй өргөдлийг хүлээн авахгүй.

7.6. Нөхөрлөл олборлолт явуулсан талбайг энэхүү журмын 10.2-т заасан шаардлагын дагуу хүлээлгэн өгсний дараа өөр газарт ашигт малтмал олборлох гэрээ байгуулах тухай өргөдлийг тухайн сум, дүүргийн Засаг даргад гаргаж болно.

7.7. Сум, дүүргийн Засаг дарга өргөдлийг хүлээн авснаас хойш ажлын 10 хоногт багтаан дараахь шаардлагыг хангасан эсэхийг тодруулна:

7.7.1. энэхүү журмын 7.4-т заасан шаардлагыг хангасан эсэх;

7.7.2. энэхүү журмын 7.3-т заасан баримт бичгийг

бүрдүүлсэн эсэх;

7.7.3. өргөдөгд заасан талбай нь энэхүү журмын 5.1-д заасан газрын хязгаарт багтаж байгаа эсэх;

7.7.4. тухайн нөхөрлөл өмнө нь олборлолт явуулж байсан бол байгаль орчны техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг энэ журмын 10.2-т заасны дагуу бүрэн хийсэн эсэх.

7.8. Өргөдөл, хавсаргасан баримт бичиг энэхүү журмын 7.7-д заасан шаардлагыг хангасан тохиолдолд өргөдлийн бүртгэгдсэн дарааллын дагуу Ашигт малтмал олборлох гэрээ байгуулна.

Найм. Ашигт малтмал олборлох гэрээ байгуулах

8.1. Энэхүү журмын 5.1-д заасан газарт ашигт малтмал олборлох нөхөрлөл нь тухайн сум, дүүргийн Засаг даргатай бичгээр гэрээ байгуулна.

8.2. Гэрээнд дараахь асуудлыг тусгана:

8.2.1. талуудын эрх, үүрэг, хариуцлага;

8.2.2. талбайн байршил, хэмжээ;

8.2.3. гэрээний хугацаа, түүнийг сунгах нөхцөл;

8.2.4. энэхүү журмын 5.1-д заасан газрыг ашиглуулах нөхцөл;

8.2.5. байгаль орчныг нөхөн сэргээх чиглэлээр хийх ажлын төлөвлөгөө, төсөв, зардлын эх үүсвэрийн баталгаа;

8.2.6. олборлох ашигт малтмалын төрөл;

8.2.7. бичил уурхайн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм, заавар, эрүүл ахуйн норм, стандартыг мөрдөх нөхцөл;

8.2.8. нөхөрлөлийн гишүүдийг нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалд хамруулах нөхцөл;

8.2.9. хилийн цорьт болон аюултай бусдас шиглэхгүй байх тухай үүрэг;



8.2.10. тэсэрч, дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг ашиглахдаа зөвхөн тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдээр хийлгэх үүрэг;

8.2.11. гэрээг цуцлах болон дуусгавар болох үндэслэл;

8.2.12. хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрмийг зөрчсөнөөс үүсэн гарах хариуцлага;

8.2.13. талбайн байгаль орчныг хамгаалах, хог хаягдлын цэг байгуулах, нөхөрлөлийн гишүүд, тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, тогтоосон суурьшлын бүсэд амьдрах талаархи үүрэг;

8.2.14. бусад зүйл.

Ес. Нөхөрлөлийн олборлосон ашигт малтмалыг борлуулах

9.1. Нөхөрлөлийн олборлосон ашигт малтмалыг холбогдох хууль тогтоомжийн дагуу худалдах, худалдан авах эрх бүхий хуулийн этгээдэд худалдана.

Арав.Талбайг буцааж хүлээлгэн өгөх

10.1. Нөхөрлөл дараахь нөхцөлд талбайг буцааж хүлээлгэн өгнө:

10.1.1. ашигт малтмалын нөөц эдийн засгийн хувьд ашиггүй гэж үзсэн;

10.1.2. хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөлөөс шалтгаалан олборлолтыг үргэлжлүүлэх боломжгүй болсон тухай улсын байцаагчийн дүгнэлт гарсан;

10.1.3. нөхөрлөл талбайг хүлээлгэн өгөх хүсэлт гаргасан;

10.1.4. нөхөрлөлтэй байгуулсан гэрээг цуцалсан;

10.1.5. нөхөрлөлтэй байгуулсан гэрээг хугацаанаас нь өмнө цуцалсан нь тухайн нөхөрлөлийг олборлолт хийсэн талбайдаа техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх үүргээс чөлөөлөхгүй.

10.2. Нөхөрлөл талбайг буцааж хүлээлгэн өгөхийн өмнө тухайн



талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлыг зааврын дагуу хийж, байгаль орчны хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гаргуулан, сум, дүүргийн Засаг даргын томилсон комисст хүлээлгэн өгнө. Урьд нь том уурхайн олборлолт явуулаад нөхөн сэргээлт хийгээгүй газарт олборлолт явуулж байгаа тохиолдолд зөвхөн нөхөрлөлийн олборлолт хийсэн газарт нөхөн сэргээлтийг зааврын дагуу хийнэ.

10.3. Нөхөрлөл болон нутгийн захиргааны байгууллага нь нөхөн сэргээлтийн дундын сангийн мөнгөн хөрөнгийг зөвхөн энэхүү журмын 10.2-т заасан зориулалтаар хамтран захиран зарцуулна.

Арван нэг, Бичил уурхайгаар ашигт малтмал олборлоход
хориглох зүйл

11.1. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагаанд дараахь зүйлийг хориглоно:

11.1.1. 18 нас хүрээгүй иргэнийг ажиллуулах;

11.1.2. хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн дүрэм зөрчих;

11.1.3. гэрээгээр олгосон газраас бусад газарт ашигт малтмал агуулсан шороо, хүдрийг угааж баяжуулах;

11.1.4. албан татвар төлөхөөс зайлсхийх;

11.1.5. нөхөрлөлийн гишүүн бус этгээдийг оролцуулах;

11.1.6. химийн хорт болон аюултай бодис ашиглах;

11.1.7. тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдээр гүйцэтгүүлэхээс бусад тохиолдолд тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл ашиглах;

11.1.8. нөхөрлөлд гэрээгээр олгосон талбайг зориулалт бусаар ашиглах, бусдад шилжүүлэх, барьцаалах, худалдах;

11.1.9. байгаль орчинд ноцтой сөрөг нөлөө үзүүлэх;

11.1.10. ашигт малтмал олборлолтын үйл ажиллагаанд 500 см^3 -ээс дээш багтаамжтай дотоод шаталтат хөдөлгүүр бүхий механизмдыг ашиглах;

11.1.11. энэ журмын 5.3-т заасан гурвалсан гэрээг



байгуулахгүйгээр ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн талбайд зэрэгцэн үйл ажиллагаа явуулах;

11.1.12. энэ журмын 5.5-д заасан гурвалсан гэрээ байгуулахгүйгээр дангаараа далд уурхай ашиглах.

Арван хоёр. Онцгой нөхцөл

12.1. Нөхөрлөлийн алтны үндсэн ордоос олборлосон хүдрийг баяжуулах үйл ажиллагааг явуулах газрын байршлыг геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, мэргэжлийн хяналтын байгууллага хамтран тогтооно.

12.2. Баяжуулах цехэд тавигдах техникийн нөхцөлийг геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага боловсруулна.

12.3. Тогтоосон газарт баяжуулах цехэд тавигдах техникийн нөхцөлийн шаардлага хангасан аж ахуйн нэгжийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал сонгон шалгаруулна.

12.4. Цехийг геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, мэргэжлийн хяналтын байгууллагын төлөөллийг оролцуулсан ажлын хэсэг техникийн нөхцөлийн дагуу ашиглалтад хүлээж авна.

12.5. Баяжуулах цех байгуулахаар шалгарсан аж ахуйн нэгж нь тухайн газрын байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн дагуу хийлгэсэн байна.

Арван гурав. Хяналт тавих, хариуцлага хүлээлгэх

13.1. Энэхүү журмын хэрэгжилтэд мэргэжлийн хяналтыг хэрэгжүүлэх төв болон орон нутгийн байгууллага, нутгийн захиргаа, өөрөө удирдах байгууллага болон цагдаагийн байгууллага, орон нутгийн байгаль орчны болон бичил уурхайн асуудал хариуцсан ажилтан хяналт тавина.

13.2. Энэхүү журмыг зөрчсөн иргэн, хуулийн этгээд албан тушаалтан эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Ашигт малтмалын тухай хуулийн 6б.1.9-д заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2010 оны 12 дугаар
сарын 8-ны өдөр

Дугаар 318

Улаанбаатар
хот

Хөтөлбөр батлах тухай

Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Үндэсний түргэн тусламжийн сүлжээ” хөтөлбөрийг хавсралт ёсоор баталсугай.
2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг улсын хэмжээнд удирдан зохион байгуулахыг Эрүүл мэндийн сайд С.Ламбаа, Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо (Ч.Хашнулуун)-нд даалгасугай.
3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг 2011 оноос эхлэн жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, тухайн жилийн төсвийн төсөлд тусгах, хувийн хөрөнгө оруулалтыг татан оролцуулах, хандивлагч орон, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайд С.Баярцогт, Эрүүл мэндийн сайд С.Ламбаа, Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо (Ч.Хашнулуун)-нд үүрэг болгосугай.
4. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүрийн II улиралд багтаан Засгийн газарт танилцуулж байхыг Эрүүл мэндийн сайд С.Ламбаад даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

С.ЛАМБАА

Засгийн газрын 2010 оны 318 дугаар
тогтоолын хавсралт

“ҮНДЭСНИЙ ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН СҮЛЖЭЭ” ХӨТӨЛБӨР

Нэг, Эмнэлгийн түргэн тусламжийн өнөөгийн байдал, тулгамдсан асуудал, хөтөлбөр боловсруулах үндэслэл

Манай улсад түргэн тусламжийн дуудлагын тоо жил ирэх тутам нэмэгдэж, жилд дунджаар 600 мянга гаруй дуудлага гарч байгаагаас



25 хувь нь нийслэлд, 75 хувь нь хөдөө орон нутагт тохиолдож байна. Эмнэлгийн түргэн тусламжийн салбарт 2009 оны байдлаар нийт 185 их эмч, 56 бага эмч, 126 сувилагч, 277 жолооч ажиллаж байна. Өнгөрсөн оны байдлаар улсын хэмжээнд нийт 615844 дуудлага авснаас 480262 тохиолдолд өвчтөнд газар дээр нь эмнэлгийн тусламж үзүүлж, 2220 тохиолдолд эмч очихоос өмнө өвчтөн нас барсан байна. Монгол Улсын хүн амын нас баралтын зонхилох шалтгааны дотор яаралтай тусламж шаардлагатай цусны эргэлтийн тогтолцооны өвчин, осол гэмтэл орж байна.

Түргэн тусламжийн автомашины 90 гаруй хувь нь зориулалтын дагуу тоноглогдоогүй, хуучирсан, багаж, тоног төхөөрөмжийн хангамж муу, дэд бүтэц, үйлчилгээний стандарт, эмнэлзүйн удирдамж дутмаг, энэ салбарын эмч, мэргэжилтэн нь яаралтай тусламжийн технологи, арга барилд бүрэн мэргэшээгүй байдал нөлөөлж байна. Эмнэлгийн яаралтай тусламжийн мэргэшсэн эмч, сувилагч, парамедик тусгайлан бэлтгэх тогтолцоо бүрдээгүй байна.

Нийслэлийн хүн амын өсөлттэй уялдан дуудлагын тоо жилээс жилд нэмэгдэн 2009 оны байдлаар 144908 дуудлаганд үйлчилсэн нь өмнөх оноос 20000 гаруй дуудлагаар илүү байна. Хүн ам шигүү суурьшсан Сонгинохайрхан болон Баянзүрх дүүрэгт нийт дуудлагын 45,2 хувь ногдож байна. Олон улсын жишгээр 10 мянган хүн ам тутамд нэг түргэн тусламжийн баг үйлчилдэг байхад нийслэлийн хэмжээнд өдөрт 40 хүрэхгүй автомашин үйлчилж байгаа нь олон улсын жишгээс 3 дахин бага байна. Өнөөгийн байдлаар нийслэлийн хэмжээнд хүлээн авсан нийт дуудлагын 76.2 хувь нь 20 минутаас дээш хугацаагаар хүлээлгэсэн байна.

Иймд түргэн тусламжийн үйлчилгээг үр дүнтэй бүтэц, зохион байгуулалтад оруулах, менежментийг сайжруулах, техник, багаж, тоног төхөөрөмжийг шинэчлэх, боловсон хүчний мэдлэг, чадварыг дээшлүүлэх замаар олон улсын жишигт ойртсон нэгдсэн тогтолцоо бий болгох шаардлагатай байгаа тул “Үндэсний түргэн тусламжийн сүлжээ хөтөлбөр”-ийг (цаашид “хөтөлбөр” гэнэ) боловсруулсан болно.

Энэхүү хөтөлбөрт хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

-“түргэн тусламжийн үйлчилгээ” гэж цочмог өвчин эмгэг, осол гэмтэл, хордлого, жирэмслэлт, төрөлтийн үед эмнэлгийн яаралтай анхны тусламжийг газар дээр нь болон тээвэрлэлтийн явцад үзүүлэн, эмнэлэгт хүргэх үйлчилгээг;

-“эмнэлгийн яаралтай тусламж” гэж хүний амь насанд аюултай



аливаа эмгэгийг оношлох, эмчлэх, сэхээн амьдруулах, хүндрэлээс сэргийлэхэд чиглэсэн эмчийн дангаар болон эмнэлгийн бусад мэргэжилтэнтэй хамтран гүйцэтгэх хойшлуулшгүй үйл ажиллагааг;

-“тамшгийн үеийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ” гэж хүн амыг олноор хамарсан халдварт өвчний дэгдэлт болон аюулт үзэгдлийн үед голомтыг хязгаарлах, цомхотгох, хохирлыг багасгахад чиглэсэн эрүүл мэндийн байгууллагын дангаар болон төр, олон нийт, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдтэй хамтарсан тусламж, үйлчилгээг;

-“Үндэсний түргэн тусламжийн сүлжээ” гэж эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэдэх сүлжээний төвтэй орчин үеийн харилцаа холбооны тоног төхөөрөмжөөр холбогдсон эрүүл мэндийн бүх шатны байгууллагын дуудлага хүлээн авах, бүртгэх, иргэдэд эмнэлгийн яаралтай болон түргэн тусламжийг шуурхай үзүүлэх нэгдсэн удирдлага, зохицуулалт бүхий үйлчилгээг.



Хоёр: Хөтөлбөрийн зорилго, зорилт

2.1 Хөтөлбөрийн зорилго нь хүн амд түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын тогтолцоог боловсронгуй болгох, түргэн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж, чадавхийг сайжруулж Үндэсний түргэн тусламжийн сүлжээ байгуулахад оршино.

2.2 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд дараахь зорилтыг дэв-



шүүлж байна:

2.2.1. Нэгдүгээр зорилт: түргэн тусламж үзүүлж байгаа эрүүл мэндийн байгууллагын тогтолцоог боловсронгуй болгож, Үндэсний түргэн тусламжийн сүлжээ байгуулах;

2.2.2. Хоёрдугаар зорилт: түргэн тусламж үзүүлж байгаа эрүүл мэндийн байгууллагын чадавхийг сайжруулах;

2.2.3. Гуравдугаар зорилт: салбар хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах;

2.2.4. Дөрөвдүгээр зорилт: түргэн тусламжийн үйл ажиллагааны талаархи мэдээллийг боловсронгуй болгох, эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг хөгжүүлэх.

Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарчим

3.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дараахь зарчмыг баримтална:

3.1.1. түргэн тусламжийн үйлчилгээний шуурхай, бэлэн байдлыг хангаж ажиллах;

3.1.2. түргэн тусламжийн үйлчилгээ нь хүн амд тэгш хүртээмжтэй, олон нийтийн оролцоонд суурилсан байх;

3.1.3. түргэн тусламжийн үйлчилгээ нь хүнлэг энэрэнгүй байх;

3.1.4. эмнэлгийн яаралтай болон түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлэхдээ эмнэлгийн ажилтны ёс зүйн хэм хэмжээг баримтлах;

3.1.5. өвчтөний аюулгүй байдал, эрхийг хангаж үйлчлэх.

Дөрөв. Хөтөлбөрийн зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хүрэх үр дүн

4.1 Түргэн тусламж үзүүлж байгаа эрүүл мэндийн байгууллагын тогтолцоог боловсронгуй болгож, үндэсний түргэн тусламжийн сүлжээ байгуулах нэгдүгээр зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.1.1. эмнэлгийн түргэн тусламж үзүүлж байгаа эрүүл



мэндийн байгууллагын үйл ажиллагаа, одоогийн тогтолцоонд хяналт-шөнжилгээ хийж үнэлгээ өгөх, дүгнэлт гарган үндэсний түргэн тусламжийн сүлжээ байгуулах, санхүүжилтийн асуудлыг шийдвэрлүүлэх;

4.1.2. түргэн тусламжийн үйлчилгээг улсын хэмжээнд мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангаж, дэмжлэг үзүүлж ажиллах үүрэг бүхий сүлжээний төвийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дэргэд байгуулах;

4.1.3. эмнэлгийн яаралтай болон түргэн тусламжийн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлж бодлого боловсруулах болон бусад шаардлагатай асуудлаар санал, дүгнэлт, зөвлөмж гаргахад зөвлөх чиг үүрэг бүхий орон тооны бус мэргэжлийн салбар зөвлөлийг Эрүүл мэндийн яаманд байгуулан ажиллуулах;

4.1.4. түргэн тусламжийн сүлжээний байгууллагын бүтэц, үйл ажиллагааны стандарт, удирдамж боловсруулан хэрэгжүүлэх;

4.1.5. нийслэлийн хүн амд түргэн тусламжийн үйлчилгээг ойртуулах, шуурхай байдлыг хангах зорилгоор Сонгинохайрхан, Хан-Уул, Чингэлтэй дүүрэгт түргэн тусламжийн салбар байгуулах;

4.1.6. нийслэлийн түргэн тусламж, онцгой байдал, цагдаагийн байгууллагын хамтарсан мэдээлэл, шуурхай удирдлагын төвийн үйл ажиллагааг өргөтгөх;

4.1.7. Ховд, Өвөрхангай, Дорнод, Орхон аймагдахь бүсийн оношилгоо эмчилгээний төвөөс бүсийн аймаг, сумдын хүн амд түргэн тусламжийн үйлчилгээ шуурхай хүргэх зорилгоор иж бүрэн тоноглогдсон явуулын түргэн тусламжийн үйлчилгээг шинээр нэвтрүүлэх;

4.1.8. Төв, Архангай, Өвөрхангай, Хэнтий, Дорноговь, Сэлэнгэ, Дархан-Уул, Орхон, Говьсүмбэр аймгийн "Мянганы зам" дагасан сумдын эмнэлэг болон нийслэлийн алслагдсан 3 дүүргийн нэгдсэн эмнэлгийн түргэн тусламжийн чадавхийг сайжруулах.

Хүрэх үр дүн: Хүн амд үзүүлэх эмнэлгийн яаралтай болон түргэн тусламжийн үйлчилгээний удирдлага, зохион байгуулалт боловсронгуй болж үндэсний хэмжээний нэгдсэн сүлжээ бий болно.

4.2. Түргэн тусламж үзүүлж байгаа эрүүл мэндийн байгууллагын чадварыг сайжруулах хөёрдугаар зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.2.1. анагаах ухааны болон сувилахуйн сургуулийн төгсөлтийн өмнөх болон дараахь сургалтын хөтөлбөрт эмнэлгийн яаралтай болон гамшиг, онцгой байдлын үед үзүүлэх тусламж, үйлчилгээний хичээлийг оруулах;

4.2.2. эмнэлгийн яаралтай тусламж үзүүлж байгаа эмч, сувилагчийг мэргэшүүлэх, тэдгээрийг нарийн мэргэжлээр гадаадад сургах;

4.2.3. түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлэх мэргэшсэн ажилтан /парамедик/-ыг сургах;

4.2.4. эмнэлгийн анхны тусламжийн мэдлэг олгох сургалтыг байгууллага, аж ахуйн нэгжид явуулж, тогтмолжуулах;

4.2.5. эмнэлгийн яаралтай болон түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлж байгаа эмч, эмнэлгийн мэргэжилтэн, мэргэшсэн ажилтны хөдөлмөрийн норм, нормативыг шинэчлэн тогтоож, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;

4.2.6. сум, өрхийн эмч, эмнэлгийн мэргэжилтнийг эмнэлгийн яаралтай болон түргэн тусламжийн чиглэлээр ажлын байран дээр нь дадлагажуулах сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах;

4.2.7. зайн оношилгоог ашиглан клиникийн болон төрөлжсөн мэргэжлийн эмнэлгээс бүсийн оношилгоо, эмчилгээний төв, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, сумын эмнэлэгт зөвлөгөө өгөх үйл ажиллагааг нэвтрүүлэх;

4.2.8. эмнэлгийн яаралтай болон түргэн тусламжид хэрэглэх нэн шаардлагатай эм, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлэх, гамшиг болон онцгой байдлын үед хэрэглэх нөөцийг бүрдүүлэх;

4.2.9. эмнэлэг болон түргэн тусламжийн байгууллагын үйл ажиллагааны уялдааг сайжруулах зорилгоор орчин үеийн харилцаа холбооны техник, тоног төхөөрөмжөөр хангах;

4.2.10. түргэн тусламжийн үйлчилгээг эмнэлгийн зориулалтаар тоноглогдсон автомашинаар хангах, нисдэг тэрэг, онгоцоор үйлчлэх нөхцөлийг бүрдүүлэх;

4.2.11. эмнэлгийн яаралтай болон түргэн тусламжийн үйлчилгээний санхүүжилт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зорилгоор



түргэн тусламжийн зарим үйлчилгээг иргэний эрүүл мэндийн даатгалд хамруулах асуудлыг судлан шийдвэрлэх;

4.2.12. эмнэлгийн яаралтай болон түргэн тусламжийн чиглэлээр төсөл, хөтөлбөр боловсруулан олон улсын болон гадаад, дотоодын хандивлагч байгууллагуудтай хамтран ажиллах;

4.2.13. түргэн тусламжийн үйл ажиллагаанд чанарын удирдлагын тогтолцоог бүрдүүлэн, үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтийг боловсруулан мөрдүүлэх;

4.2.14. өвчтөнд газар дээр нь болон тээвэрлэлтийн явцад үзүүлэх түргэн тусламж үйлчилгээний төрөл жагсаалт, эмнэлзүйн удирдамж, стандартыг боловсруулах;

4.2.15. сум, багийн хүн ам эмнэлгийн яаралтай тусламж болон төрөлжсөн мэргэжлийн эмчийн үйлчилгээг шуурхай авах боломжийг бүрдүүлэх зорилгоор зайн оношилгоо, эмчилгээ болон хөдөлгөөнт эмнэлгийг ажиллуулах;

4.2.16. байгалийн болон хүний үйл ажиллагаанаас үүдэн гарах гамшиг, нийтийг хамарсан гэнэтийн аюул, ослын үеийн эрүүл мэндийн байгууллагын аюулгүй, найдвартай ажиллагааг хангах зорилгоор бэлэн байдал, хариу арга хэмжээ, нөхөн сэргээх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх.

Хүрэх үр дүн: Эмнэлгийн яаралтай болон түргэн тусламж үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын чадавхи нэмэгдэж тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж сайжирна.

4.3 Салбар хоорондын үйл ажиллагааны уялдаа, холбоог сайжруулах гуравдугаар зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.3.1. бүх шатлалын эрүүл мэндийн байгууллагын түргэн тусламжийн үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх, салбар хоорондын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах асуудлыг журамлах;

4.3.2. хөрш болон бүс нутгийн улс орнуудын яаралтай болон түргэн тусламжийн байгууллагатай хамтран ажиллах, харилцан туршлага солилцох, боловсон хүчнийг мэргэшүүлэх, техник технологийг нь нутагшуулах;

4.3.3. түргэн тусламж өвчтөнд шуурхай, цаг алдалгүй



очих нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор иргэдийн оршин суугаа хороолол, гудамжны гэрэлтүүлэг, хаягжилтыг шинэчлэн сайжруулж, замын саадыг арилгах, түүнчлэн түргэн тусламжийн үйлчилгээнд тээврийн хэрэгсэл, хүн хүч дайчлах, шатахуунаар хангах чиглэлээр бүх шатны Засаг дарга нартай гэрээ байгуулан ажиллах;

4.3.4. түргэн тусламжийн үйлчилгээнд аж ахуйн нэгж, иргэдээс гаргаж байгаа санаачилга, оролцоог дэмжих, "Шуурхай бүлэг 105", өрхийн эмнэлэг болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагыг оролцуулах;

4.3.5 түргэн тусламжийн үйлчилгээнд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, лавлагаат тусламж, зөвлөгөө өгөх, эмнэлгийн яаралтай болон түргэн тусламжид хэрэглэх нэн шаардлагатай эм, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлэх асуудлыг төр-хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэх;

4.3.6. хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг үндэсний бусад хөтөлбөр, стратеги, төслийн хэрэгжилттэй уялдуулах.

Хүрэх үр дүн: Төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, аж ахуйн нэгж, олон нийтийн оролцоо нэмэгдэж, салбар хоорондын хамтын ажиллагаа, уялдаа холбоо сайжирна.

4.4. Түргэн тусламжийн үйл ажиллагааны талаархи мэдээллийг боловсронгуй болгох, эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг хөгжүүлэх дөрөвдүгээр зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.4.1. түргэн тусламжийн үйлчилгээний нөхцөл байдлын дүн шинжилгээ болон үр ашиг, өртөг зардлын судалгаа хийж, дүгнэлт гаргах;

4.4.2. түргэн тусламжийн үйлчилгээний талаархи үндэсний статистик мэдээллийн үзүүлэлтийг боловсронгуй болгох, нэгдсэн сан байгуулах;

4.4.3. яаралтай болон түргэн тусламжийн чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг мэргэжлийн зөвлөл болон холбоогоор гүйцэтгүүлэх;

4.4.4. яаралтай болон түргэн тусламжийн үйлчилгээний талаархи статистик мэдээллийн магадлалыг үнэлэх түүвэр судалгааг сонгосон эрүүл мэндийн байгууллагыг хамруулан 3-5 жил тутамд зохион байгуулах;



4.4.5. түргэн тусламжийн үйл ажиллагааг боловсронгуй болгох эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг хөхиүлэн дэмжих асуудлыг төсвийн болон бусад санхүүжилтээр шийдвэрлэх, судалгааны ажлын тэтгэмж олгох;

4.4.6. болзошгүй гамшиг, онцгой байдал, шинэ болон шинээр сэргэж байгаа халдварын дэгдэлтийн үеийн яаралтай болон түргэн тусламжийн хэрэгцээ, нөөц, бэлэн байдалд судалгаа хийж дүгнэлт, зөвлөмж гаргах;

Хүрэх үр дүн: Эмнэлгийн яаралтай болон түргэн тусламжийн талаар мэдээллийн сантай болж баримт, нотолгоонд тулгуурласан бодлого, арга хэмжээг авч хэрэгжүүлдэг болсон байна.

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, үе шат, санхүүжилт

5.1. Үндэсний хөтөлбөрийг 2010-2016 онд 2 үе шаттайгаар хэрэгжүүлнэ:

Нэгдүгээр үе шат - 2010-2013 он

Хоёрдугаар үе шат - 2014-2016 он

5.2. Хөтөлбөрийн санхүүжилтийг дараахь эх үүсвэрээс бүрдүүлнэ:

5.2.1. улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө;

5.2.2. гадаад, дотоодын төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив, тусламж;

5.2.3. олон улсын байгууллага, хандивлагч орны эзэл, тусламж болон төсөв, хөтөлбөрийн санхүүжилт;

5.2.4. бусад эх үүсвэр.

Зургаа. Хөтөлбөр хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд удирдлага, зохицуулалтаар хангах, хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэх асуудлыг эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах ажлыг яаралтай тусламжийн мэргэжлийн зөвлөл, түргэн тусламжийн сүлжээний төв зохион байгуулна.



Орон нутгийн түвшинд хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг тайлагнах асуудлыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар болон бусад мэргэжлийн байгууллагатай бүх шатны Засаг дарга хамтран гүйцэтгэнэ.

Долоо. Хөтөлбөрийн хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт

7.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг дараахь шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:

№	Үзүүлэлт	2010 оны суурь түвшин /хувиар/	2013 онд хүрэх түвшин /хувиар/	2016 онд хүрэх түвшин /хувиар/	Мэдээний эх үүсвэр
1	Осоол, гэмтлийн дуудлагад эмч очихоос өмнө нас барсан тохиолдлын хувь	3.03	2.8	2.0	Эрүүл мэндийн газрын мэдээ
2	Яаралтай дуудлага хүлээж аваад 20 минутын дотор тусламж үзүүлсэн тохиолдлын хувь	Судалгаа авсан оны суурь үзүүлэлт 23.8	35	50	
3	Түргэн болон яаралтай тусламжийн чиглэлээр гадаад оронд бэлтгэгдсэн сургалч багшийн тоо	-	2	4	ЭМЯ, бусад вандын мэдээлэл
Эмнэлгийн яаралтай тусламжийн мэргэшсэн боловсон хүчний тоо					
4	Их эмчийн тоо	-	40	80	Эрүүл мэндийн газрын мэдээ
		-	60	120	
5	Бэлтгэгдсэн яаралтай тусламжийн мэргэшсэн ажилтан /парамедики-ы тоо	-	130	260	.



6	Анагаах ухааны боловсрол олгох сургалтын хөтөлбөрт туслагдсан эмнэлгийн яаралтай тусламжийн хичээлийн цаг /багц цагаар/	1 багц цаг	5 багц цаг	8 багц цаг	ЭМШУИС-ийн Сургалтын албаны мэдээлэл
7	Сувихлахуйн сургалтын хөтөлбөрт туслагдсан эмнэлгийн яаралтай тусламжийн хичээлийн цаг /багц цагаар/	-	1 багц цаг	2 багц цаг	
8	Эмнэлгийн яаралтай болон түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлэх стандарт, удирдамж	12	24	36	Эрүүл мэндийн газрын мэдээ
9	Түргэн тусламжийн үйлчилгээнд ашиглагдаж байгаа зориулалтын автомашинны тоо, хувь	135 /20/	168 /25/	202 /30/	ЭМЯ-ны мэдээлэл
10	Эмнэлгийн яаралтай тусламжийн үйл ажиллагаанд ашиглах, зайн оношилгооны эмчилгээний иж бүрэн тоноглогдсон автомашинны тоо	-	3	5	
11	Яаралтай тусламжийн нисдэг тээвэр, онгоцны тоо	-	1	1	
12	Телемедицин нэвтрүүлсэн эмнэлгийн яаралтай тусламжийн нэгжийн тоо	-	21	35	
13	Нийслэлд шинээр байгуулах түргэн тусламжийн салбар	1	3	2	

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2010 оны 12 дугаар
сарын 15-ны өдөр

Дугаар 325

Улаанбаатар
хот

Жагсаалт батлах тухай

"Бизнесийн орчны шинэтгэлийн жил"-ийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор, Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйл, Барилгын тухай хуулийн 5.1.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хүчингүй болсонд тооцох аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн жагсаалтыг 1 дүгээр хавсралт, төрийн бус байгууллагад гэрээний үндсэн дээр хариуцуулан гүйцэтгүүлэх зөвшөөрлийн жагсаалтыг 2 дугаар хавсралт, барилга барих зөвшөөрөл, баталгаажуулалтад гарын үсэг зурах албан тушаалтны жагсаалтыг 3 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Энэ тогтоолын 2 дугаар хавсралтад заасан зөвшөөрөл олгох үйл ажиллагааг гэрээний үндсэн дээр төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажлыг шуурхай зохион байгуулж, яам, Засгийн газрын агентлагийн хариуцах зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх чиглэл баримтлан ажиллахыг тухайн асуудлыг эрхэлсэн Засгийн газрын гишүүдэд даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан өмнө нь Засгийн газрын тогтоол болон сайдын тушаал, Засаг даргын захирамжаар баталж мөрдүүлсэн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, түүнтэй холбоотой эрх зүйн актыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэх арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүн, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгаж, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд зөвлөсүгэй.

4. Хуульд зааснаас бусад тохиолдолд аж ахуйн аливаа үйл ажиллагаатай холбогдсон зөвшөөрөл, лиценз, эрх олгох, дүгнэлт гаргах, бүртгэл явуулах, төлбөр, хураамж авах болон эдгээр асуудлаар эрх зүйн акт гаргахгүй байх, хуульд заасан зөвшөөрлийг нарийвчлан зохицуулах нэрийн дор нэр төрөл, тоо хэмжээг нь нэмэгдүүлэхгүй байхыг Засгийн газрын гишүүн, аймаг, нийслэлийн Засаг дарга нар, төрийн захиргааны байгууллага болон нутгийн захиргааны байгууллагын удирдлагад үүрэг болгож, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд зөвлөсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**МОНГОЛ УЛСЫН
ШАДАР САЙД**

М.ЭНХБОЛД

Засгийн газрын 2010 оны 325 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт

**ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ АЖ АХУЙН
ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРЛИЙН
ЖАГСААЛТ**

№	Зөвшөөрлийн нэр
1	Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн хэмжилт, судалгаанд гаргах хөдөлмөрийн эрүүл ахуйн дүгнэлт
2	Караокеий чиглэлээр үйл ажиллагаа явуулахад өгөх тодорхойлолт
3	Согууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх үйл ажиллагаа эрхлэх хүсэлт гаргасан аж ахуйн нэгжид зөвшөөрөл олгоход цагдаагийн байгууллагаас гаргах тодорхойлолт
4	Барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаа эрхлэхэд цагдаагийн байгууллагаас гаргах дүгнэлт
5	Соёлын төвийг улсын бүртгэлд бүртгэж гэрчилгээ олгох
6	Төв замын "С", "В" зөвшөөрөл, Түр зөвшөөрөл "С", "В"
7	Интернэт, цахим тоглоомын үйлчилгээ эрхлэхийг хүссэн ажахуйн нэгж, иргэнд цагдаагийн байгууллагаас олгох тодорхойлолт
8	Үржлийн мал, амьтан тэдгээрийн үр, үр хөврөл экспортлох, импортлох үед урьдчилсан хяналт тавьж дүгнэлт гаргах
9	Үржлийн мал, амьтан тэдгээрийн үр, хөврөл экспортлох, импортлоход тусгай зөвшөөрөл олгох, хугацаа сунгахад дүгнэлт гаргах
10	Тарималжуулан ургуулсан ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эдийг гадаадад гаргах гэрчилгээ
11	Тарималжуулан ургуулсан ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эдийг гадаадаас оруулах гэрчилгээ
12	Бүтээгдэхүүнийг тохирлын үнэлгээнд хамруулах тухай мэдэгдэл
13	Мэдрэллэл холбооны бүсийн сүлжээ байгуулах түүнийг ашиглах тусгай зөвшөөрөл

№	Зөвшөөрлийн нэр
14	Үүрэн холбооны сүлжээ байгуулах, түүнийг ашиглах тусгай зөвшөөрөл
15	Шуудан холбооны хот хоорондын сүлжээ байгуулах, түүнийг ашиглах тусгай зөвшөөрөл
16	Цахилгаан, шуудан холбооны үйлчилгээний цэг, салбарыг үндсэн сүлжээ эзэмшигчтэй буюу бусад үйлчлэгчтэй холболтын гэрээний үндсэн дээр түрээслэх буюу бие даан байгуулах тусгай зөвшөөрөл
17	Үүрэн телефон холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл
18	Утасгүй телефон холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл /WLL, PHS гэх мэт/
19	Улс хоорондын суваг, шугам түрээслүүлэх үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл
20	Мэдээлэл лавлагааны тусгай дугаарын менежментийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл
21	Шуудангийн тоног төхөөрөмж үйлдвэрлэх, эрхлэх тусгай зөвшөөрөл /шуудангийн хайрцаг, захидлын дугтуй, сав, баглаа боодол нийлүүлэх, үйлдвэрлэх/
22	Шуудангийн захиалгат хүргэлтийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл
23	Улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл
24	Шуудангийн нэмэлт үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл
25	Шуудангийн ложистик үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл
26	Улс хоорондын шуудангийн илгээлтийн үйлчилгээг чиглэсэн маршрутаар эрхлэх тусгай зөвшөөрөл
27	Интернэтийн төв ажиллуулах тусгай зөвшөөрөл
28	Техник хангамж болон программ хангамж нийлүүлэх үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл



№	Зөвшөөрлийн нэр
29	Сүлжээний болон төгсгөлийн төхөөрөмжийн засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл
30	Холбооны тоног төхөөрөмж үйлдвэрлэх, угсрах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл
31	Харилцаа холбооны зөвлөх үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл
32	Электрон тоног төхөөрөмжийн угсралт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл
33	Тусгай дугаар ашиглан лавлах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл
34	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тайланг хүлээн авч зөвшөөрөл олгох
35	Уулын ажлын тайланг хянаж зөвшөөрөх
36	Адууны ясны гурил импортлох, экспортлоход олгох гэрчилгээ
37	Загас экспортлоход олгох мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээ
38	Зэрлэг шувуу экспортлоход олгох мал эмнэлгийн эрүүл мэндийн гэрчилгээ
39	Тэжээвэр шувуунд олгох мал эмнэлгийн гэрчилгээ
40	Нохой, муурыг хилээр нэвтрүүлэхэд олгох мал эмнэлгийн гэрчилгээ
41	Төвлөрсөн болон төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэрийн бүс тогтооход гаргах дүгнэлт
42	Хөнгөн үйлдвэрийн ажлын байрны дүгнэлт гаргах
43	Усны объектод хаягдал ус оруулах дүгнэлт гаргах
44	Таримал ургамлын үр үйлдвэрлэх үед тусгай зөвшөөрөл олгох эсэх талаар дүгнэлт гаргах
45	Импортын таримал ургамлын үрэнд урьдчилсан хяналт хийж дүгнэлт гаргах
46	Тарих үр, сортын чанарт хяналт тавьж дүгнэлт гаргах
47	Малын тэжээл үйлдвэрлэх, экспортлох, импортлоход тэжээлийн найрлага, шимт чанарт үнэлгээ өгч дүгнэлт гаргах
48	Өлөн гэдэс боловсруулах үйлдвэрт хяналт тавьж дүгнэлт гаргах
49	Малын эм, эмнэлгийн хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох үед аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд урьдчилсан хяналт тавьж дүгнэлт гаргах



№	Зөвшөөрлийн нэр
50	Малын эмийн үйлдвэрлэлийн стандарт /GMP/-ын шаардлага хангасан талаар урьдчилсан хяналт тавьж, дүгнэлт гаргах
51	Малын эм, эмнэлгийн хэрэгслийн чанарын баталгаажилтад дүгнэлт гаргах
52	Малын эм, эмнэлгийн хэрэгслийг экспортлох үед урьдчилсан хяналт тавьж дүгнэлт гаргах
53	Мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ, баталгааны тэмдэгт тодорхойлолт гаргах
54	Малын эм, эмнэлгийн хэрэгслийг худалдах үед ажлын байранд хяналт хийж, дүгнэлт гаргах
55	Ургамал хамгаалах химийн бодис, бордоог импортлохоос өмнө загвар дээжийг шинжилгээнд хамруулж дүгнэлт гаргах
56	Эм, биобэлдмэл, вакцин, оношлуур, эмийн түүхий эд, эмнэлгийн хэрэгслийг импортлох, үйлдвэрлэхэд бүтээгдэхүүний дүгнэлт гаргах
57	Эрүүл мэндийн байгууллагуудын ажлын байрны дүгнэлт
58	Эрүүл мэндийн байгууллагуудын эмнэлгийн тоног төхөөрөмжийн чанарын талаар магадлал, итгэмжлэлд гаргах дүгнэлт
59	Эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгоход гаргах дүгнэлт
60	Гадаадын харьяат эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх, зөвшөөрөл олгоход гаргах дүгнэлт
61	Биологийн идэвхт хүнсний нэмэлт бүтээгдэхүүн импортлолт, үйлдвэрлэл явуулахад бүтээгдэхүүнд гаргах дүгнэлт
62	Эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрлийг сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгоход байцаагчийн дүгнэлт
63	Хигийн боомтод баригдах барилга, байгууламжийн зураг төсөлд урьдчилсан дүгнэлт гаргах
64	Импорт, экспортын эм, эмнэлгийн хэрэгсэлд дээж авч, дүгнэлт гаргах
65	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн импорт, үйлдвэрлэл явуулах тусгай зөвшөөрөл олгох дүгнэлт



Засгийн газрын 2010 оны 325 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт

**ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГАД ГЭРЭЭНИЙ ҮНДСЭН ДЭЭР
ХАРИУЦУУЛАН ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ЗӨВШӨӨРЛИЙН ЖАГСААЛТ**

№	Зөвшөөрлийн нэр
1	Нийтийн аж ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл
2	Барилгын материалын үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл
3	Барилгын материалын үйлдвэрлэлийн технологийн зааврыг хянаж баталгаажуулах зөвшөөрөл
4	Барилгын салбарын ажилтны давтан сургалт, мэргэжлийн зэрэг олгох зөвшөөрөл
5	Авто замын материал, туршилт шинжилгээний лаборантын мэргэжлийн үнэмлэх олгох зөвшөөрөл
6	Авто замын материал туршилт шинжилгээний лаборантын шинжилгээний дүгнэлт гаргах
7	Мэргэжлийн үнэмлэх /автогрейдерчин, индүүчин/ олгох зөвшөөрөл
8	Хүнсний үйлдвэрийн ажлын байранд дүгнэлт гаргах
9	Өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл
10	Авто тээврийн салбарын мэргэшсэн болон зөвлөх инженерийн гэрчилгээ олгох

Засгийн газрын 2010 оны 325 дугаар
тогтоолын 3 дугаар хавсралт

**БАРИЛГА БАРИХ ЗӨВШӨӨРӨЛ, БАТАЛГААЖУУЛАЛТАД
ГАРЫН ҮСЭГ ЗУРАХ АЛБАН ТУШААЛТНЫ ЖАГСААЛТ**

Албан тушаалтан	Хугацаа (хоноогоор)
1. Барилга, хот байгуулалт, төлөвлөлтийн газарт байршлын схем гаргах /7 хоног/	



1.1	Хот байгуулалтын хэлтсийн дарга	1
1.2	Дүүрэг хариуцсан архитектор	2
1.3	Дулааны инженер	1
1.4	Усан хангамж, ариутгах татуурга хариуцсан мэргэжилтэн	1
1.5	Цахилгаан хангамж, холбооны инженер	1
1.6	Нийслэлийн газар зохион байгуулагч	1
2. Хот байгуулалтын мэргэжлийн комисс байршлын схем батлах /14 хоногт/		
2.1.	Улаанбаатар хотын ерөнхий архитектор	4
2.2.	Нийслэлийн Газрын албаны дарга	2
2.3.	"Улаанбаатар дулааны сүлжээ" ХК-ийн захирал	2
2.4.	Ус сувгийг удирдах газрын дарга	2
2.5.	"Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ХК-ийн захирал	2
2.6.	"Мэдээлэл, холбооны сүлжээ" ХХК-ийн захирал	2
3. Газар олгох буюу барилга барих тухай захирамж гаргах /14 хоногт/		
3.1.	Нийслэлийн Засаг дарга	14
4. Газрын алба кадастрын зураг хийх, газар эзэмших гэрээ байгуулах, газар эзэмших гэрчилгээ олгох /14 хоногт/		
4.1.	Газрын байршлын кадастрын зураг хийх	7
4.1.1	Нийслэлийн Газрын албаны хэлтсийн дарга	
4.2.	Газар эзэмших гэрээ байгуулах	5
4.2.1	Нийслэлийн Газрын албаны дарга	
4.3.	Газар эзэмших гэрчилгээ олгох	2
4.3.1	Дүүргийн Газрын албаны дарга	
5. Архитектур төлөвлөлтийн даалгавар батлах /7 хоногт/		
5.1.	Улаанбаатар хотын ерөнхий архитектор	4



5.2.	Дүүрэг хариуцсан архитектор		3
<i>6. Эскиз батлах /7 хоногт/</i>			
6.1.	Улаанбаатар хотын ерөнхий архитектор		4
6.2.	Дүүрэг хариуцсан архитектор		3
<i>7. Техникийн нөхцөл олгох /21 хоногт/</i>			
7.1.	Дулааны техникийн нөхцөл олгох		21
	7.1.1	"Улаанбаатар дулааны сүлжээ" ХК-ийн ерөнхий инженер	
7.2.	Усны техникийн нөхцөл олгох		21
	7.2.1	Ус сувгийг удирдах газрын дэд дарга	
7.3.	Цахилгааны техникийн нөхцөл олгох		21
	7.3.1.	"Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ХК-ийн ерөнхий инженер	
7.4.	Холбооны техникийн нөхцөл олгох		21
	7.4.1	Кабель шугамын ашиглалтын албаны ерөнхий инженер	
<i>8. Ажлын зураг зөвшөөрөх /39 хоногт/</i>			
8.1.	Нийслэлийн Барилга, хот байгуулалт, төлөвлөлтийн газар		6
	8.1.1	Улаанбаатар хотын ерөнхий архитектор	4
	8.1.2	Авто замын инженер	2
8.2.	Нийслэлийн Онцгой байдлын газрын гал түймэртэй тэмцэх, урьдчилан сэргийлэх хяналтын ахлах байцаагч		5
8.3.	"Улаанбаатар дулааны сүлжээ" ХК-ийн ерөнхий инженер		7
8.4.	Ус сувгийг удирдах газрын ерөнхий инженер		7



8.5.	"Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ХК-ийн ерөнхий инженер		7
8.6.	"Мэдээлэл, холбооны сүлжээ" ХХК-ийн ерөнхий инженер		7
9. Барилгын зураг төсөлд экспертиз хийх /21 хоногт/			
9.1.	Газрын харилцаа, барилга, геодези, зураг зүйн газар		
	9.1.1.	Хэлтэс, албаны дарга	21
	9.1.2.	Архитектурын эксперт	
	9.1.3.	Хийцийн эксперт	
	9.1.4.	Хөрсний инженер, геологийн дүгнэлтийн эксперт	
	9.1.5.	Инженерийн шугам, сүлжээнүүдийн эксперт	
	9.1.6.	Улс, орон нутгийн төсөв болон гадаадын хөрөнгө оруулалтын төслийн хөрөнгөөр хэрэгжих барилга байгууламжийн өртөг төсвийн эксперт	
10. Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл авах /14 хоногт/			
10.1	Барилга, техник хяналтын улсын ахлах байцаагч		14
10.2	Өргөх машин, механизмын улсын ахлах байцаагч		
10.3	Дулааны эрчим хүчний хяналтын улсын байцаагч		
10.4	Усан хангамж, ариутгах татуургын улсын байцаагч		
10.5	Цахилгаан эрчим хүчний хяналтын улсын байцаагч		
10.6	Холбооны хяналтын улсын байцаагч		
10.7	Хот, барилга архитектур төлөвлөлтийн хяналтын улсын байцаагч		
11. Барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах улсын комисс /7 хоногт/			



11.1	Улсын комиссын дарга	7
11.2	Техникийн комиссын дарга /Захиалагч/	
11.3	Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл	
11.4	Барилгын хяналтын улсын ахлах байцаагч	
11.5	Байгаль орчин, газрын харилцаа, геодезийн хяналтын улсын ахлах байцаагч	
11.6	Хот байгуулалтын хяналтын улсын ахлах байцаагч	
11.7	Өргөх машин, механизмын улсын ахлах байцаагч	
11.8	Авто замын хяналтын улсын ахлах байцаагч	
11.9	Цахилгаан эрчим хүчний байгууллагын төлөөлөл	
11.10	Дулааны эрчим хүчний байгууллагын төлөөлөл	
11.11	Ус сувгийн ашиглалтын байгууллагын төлөөлөл	
11.12	Холбоо, дохиоллын байгууллагын төлөөлөл	
11.13	Онцгой байдлын ерөнхий газрын төлөөлөл	
11.14	Зураг төслийн байгууллагын төлөөлөл	

Хаяг:

"Төрийн мэдээлэл" мөхтгэлийн редакция


Улаанбаатар-12, Төрийн ордон 124 тоот

И-мэйл: turin_medeel@parliament.mn

Утас: 767470 329612

Хэвлэлийн хуудас 2

Индекс: 14003



Улсын Их Хурлын Төлгөн үндэсний хөдөлгөөнийг хамгаалж, хөгжүүлж,
Утас 329457